



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар хороо, Хөлбөмбөгийн төв
Улаанбаатар-210646 Ш/хайрцаг-259
Утас: (976-11) 345964, 345968, Факс: (976-11) 345966
Вэб сайт: www.the-mff.mn

Улаанбаатар хот
2017 оны 05 сарын 01 өдөр
№ 09

САХИЛГЫН ХОРООНЫ ШИЙДВЭР

Сахилгын шийтгэл авах тухай

“ХҮРХРЭЭ ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ 2017” тэмцээний 2017 оны 04-р сарын 29-ны өдрийн “УЛААНБААТАР СИТИ” – “ЭФ СИ УЛААНБААТАР” багуудын тоглолтын үеэр “ЭФ СИ УЛААНБААТАР” багийн №6 дугаартай тоглогч Б.Баярбат талбайн шүүгч Ч.Жавхлантагсруу нулимсан зөрчил үйлдсэн тухай ТЗБК-оос ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч хянахад:

“ЭФ СИ УЛААНБААТАР” багийн №6 дугаартай тоглогч Б.Баярбат нь МХБХ-ны “Сахилгын Хорооны дүрэм”-ийн 10.18 “с” заалтыг зөрчсөн нь NTV телевизийн тоглолтын бичлэг, талбайн шүүгч Ч.Жавлантагсийн тайлан, тоглолтын match commissioner Б.Хаш-Эрдэнийн тайлан зэргээр нотлогдож байх тул ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. “ЭФ СИ УЛААНБААТАР” багийн №6 дугаартай тоглогч Б.Баярбатыг 2017 оны 05-р сарын 01-ны өдрөөс эхлэн 2018 оны 05-р сарын 01 хүртэл МХБХ-оос зохион байгуулсан аливаа тэмцээн уралдаанд оролцох эрхийг хасаж өнжүүлэх шийтгэл ноогдуулсугай.

Дээрхи шийдвэрийг эс зөвшөөрвөл МХБХ-ны сахилгын хорооны дүрмийн 88, 89 дэх заалтуудын дагуу давж заалдаж болно.



Ц.БАТСҮХ